

## ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ

- ◆ Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх
- ◆ Тэтгэмж олгох хугацаа, хувь хэмжээ
- ◆ Эмнэлгийн хуудас олголт
- ◆ Тэтгэмж авах хүсэлт гаргах
- ◆ Нийтлэг асуулт-хариулт



# Хөдөлмөрийн чадвар түр алдсаны ТЭТГЭМЖ авах



## Тэтгэмж авах эрх

Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэлийг төлсөн даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

## Тэтгэмж авах хугацаа, хувь хэмжээ

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг шимтгэл төлж ажилласан хугацаанаас хамааран сүүлийн бүтэн ажилласан 3 сарын хөдөлмөрийн хөлсний дунджаас доорх хувиар бодож олгоно:

Шимтгэл төлж ажилласан хугацаа	Тэтгэмж бодох хувь хэмжээ
5 хүртэл жил	50%
5-аас 14 жил	55%
15, түүнээс дээш жил	75%



Харин даатгуулагч нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан тохиолдолд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 100 хувиар бодож олгоно.

---

## Баримт бичиг

Даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- Эмнэлгийн хуудас;
- Тэтгэмж олгохыг хүссэн өргөдөл.

---

## Эмнэлгийн хуудас олголт

Ердийн болон ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан даатгуулагчид эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн хуудсыг бичиж олгоно. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг амбулаториор эмчлүүлсэн даатгуулагчид 14 хүртэл, хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд тусламж, үйлчилгээ үзүүлсэн хоногоор тус тус бичнэ.



**САНАМЖ:** Даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг тусламж, үйлчилгээ авч дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор (гадаад оронд эмчлүүлсэн тохиолдолд эх орондоо ирснээс хойш 14 хоногийн дотор) эрүүл мэндийн байгууллагаас цаасан эсвэл цахим хэлбэрээр бичүүлэн авна.

---

## Тэтгэмж авах хүсэлт гаргах

Нийгмийн  
даатгалд сайн  
дураар  
даатгуулагч:

Даатгуулагч тэтгэмж авах хүсэлтээ эмнэлгийн хуудас бичүүлснээс хойш хуанлийн 28 хоногийн дотор [daatguulageh.ndaatgal.mn](http://daatguulageh.ndaatgal.mn) эсвэл [e-mongolia.mn](http://e-mongolia.mn) веб, e-mongolia аппликейшний тусламжтайгаар цахимаар эсвэл харьяалах Нийгмийн даатгалын хэлтэстээ биеэр хандаж гаргана.

Албан  
журмын  
даатгуулагч:

Даатгуулагч эмнэлгийн хуудсыг цахимаар бичүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн хуудсыг ажил олгогч руу илгээх ба ажил олгогчоос даатгуулагчийн ХЧТА-ы тэтгэмж авах хүсэлтийг Нийгмийн даатгалын байгууллагад эмнэлгийн хуудас бичүүлснээс хойш 28 хоногийн дотор илгээнэ.



<https://daatguulagch.ndaatgal.mn>

**Алхам 1.**

**Даатгуулагчид зориулсан вебд нэвтрэх**  
“Даатгуулагчид зориулсан веб”-д бүртгүүлсэн буюу “Нийгмийн даатгал” аппликейшний эрхээр эсвэл “ДАН” танилт нэвтрэлтийн систем (удаагийн нууц код, тоон гарын үсэг, банкны эрхээр)-ээр нэвтрэнэ.

**Алхам 2.**

**Үйлчилгээ сонгох**  
“Тэтгэмж” → “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж”-ийг сонгоно.

**Алхам 3.**

**Хүсэлт илгээх**  
Дэлгэцэнд эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас харагдах ба “хүсэлт гаргах” товчийг дарж өргөдлийн маягтын дагуу мэдээллийг шалган, **утасны дугаар, и-мэйл хаяг, банкны дансны мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулна.**

Мэдээллээ үнэн зөв оруулж, тэтгэмж авах хүсэлтийг цахимаар гаргахыг зөвшөөрсөн тэмдэглэгээ хийн “хүсэлт илгээх” товчийг дарна. Амжилттай илгээгдсэн бол “хүсэлт илгээгдсэн” төлөвт шилжинэ.

**Алхам 4.**

**Хүсэлт баталгаажсан эсэхийг шалгах**  
Нийгмийн даатгалын байгууллагаас эмнэлгийн хуудасны үндэслэл, даатгуулагчийн тэтгэмж авах хүсэлтийг хянан баталгаажуулж, тэтгэмж авах эрх үүссэн тохиолдолд тэтгэмжийг хуулийн хугацаанд бодож олгоход “хүсэлт баталгаажсан”, тэтгэмж авах эрх үүсээгүй тохиолдолд “буцаасан” төлөвт тус тус шилжинэ.

[daatguulagch.ndaatgal.mn](https://daatguulagch.ndaatgal.mn) вебд бүртгүүлэх, бүртгэлээ сэргээх:

- Бүртгүүлсэн цахим шуудангаар зааврын дагуу;
- **9590-1289, 9490-1289** дугаар утсанд;
- “**Нийгмийн даатгалын мэдээлэл зөвлөгөө**” фэйсбүүк хуудсаар;
- Өөрт ойр байрлах НДХ-т тус тус хандаж шинээр бүртгүүлэх, бүртгэлээ баталгаажуулах боломжтой.

<https://e-mongolia.mn>

e-mongolia аппликейшн

### Алхам 1.

#### Порталд нэвтрэх

Нэвтрэх товч дээр дарахад ДАН Үндэсний танилт нэвтрэлтийн системийн цонх харагдах бөгөөд нэг удаагийн нууц код, тоон гарын үсэг, банкны эрхээр нэвтрэх боломжоос сонголт хийнэ.

- i. Нэг удаагийн нууц үгээр нэвтрэх бол регистрийн дугаар, нууц үгийг оруулан Таны нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаарт ирсэн 6 орон бүхий нууц кодыг оруулан бүртгүүлнэ. Бүртгэл амжилттай болсны дараа дахин нэвтэрч өөрийн мэдээллийг ашиглахыг зөвшөөрөх товчийг дарна.
- ii. Тоон гарын үсгээр нэвтрэх бол тоон гарын үсэг тээгч э-токен төхөөрөмжийг компьютерт залгаж токены нууц дугаарыг хийж Таны мэдээллийг ашиглахыг зөвшөөрөх товчийг дарна.
- iii. Банкны эрхээр нэвтрэх бол харилцагч банкыг сонгон нэвтэрч Таны мэдээллийг ашиглахыг зөвшөөрөх товчийг дарна.

### Алхам 2.

#### Үйлчилгээ сонгох

“Үйлчилгээнүүд” → ”Нийгмийн хамгаалал” → “Даатгал”  
→ “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж”-ийг сонгоно.

### Алхам 3.

#### Үйлчилгээ авах

Дэлгэцэнд эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас харагдах ба эмнэлгийн хуудасны ард байрлах “хүсэлт гаргах” товчийг дарж өргөдлийн маягтын дагуу өөрийн мэдээллийг шалган, өөрийн утасны дугаар, и-мэйл хаяг, банкны дансны мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулна.

Мэдээллээ үнэн зөв оруулж, тэтгэмж авах хүсэлтийг цахимаар гаргахыг зөвшөөрсөн тэмдэглэгээ хийн “хүсэлт илгээх” товчийг дарна. Амжилттай илгээгдсэн бол “амжилттай” төлөвт шилжинэ.

### Алхам 4.

#### Хүсэлт баталгаажсан эсэхийг шалгах

Нийгмийн даатгалын байгууллагаас эмнэлгийн хуудасны үндэслэл, даатгуулагчийн тэтгэмж авах хүсэлтийг хянан баталгаажуулж, тэтгэмж авах эрх үүссэн тохиолдолд тэтгэмжийг хуулийн хугацаанд бодож олгоход “хүсэлт баталгаажсан”, тэтгэмж авах эрх үүсээгүй тохиолдолд “буцаасан” төлөвт тус тус шилжинэ.

Хүсэлтийн төлөвийг <https://daatguulagch.ndaatgal.mn/#/main/view/medicalcert/hchta/dashboard> хаягаар шалгах боломжтой.

---

## Нийтлэг асуулт- хариулт



Ямар тохиолдолд эмнэлгийн хуудас авах вэ?

Даатгуулагч ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчин, ахуйн осол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдаж амбулаториор болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн бол эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авсан хугацааны эмнэлгийн хуудсыг олгоно.

Эмнэлгийн хуудсаа цахимаар бичүүлсэн бол тэтгэмж авах хүсэлтээ цахимаар гаргах уу?

Тийм. Эрүүл мэндийн байгууллагаас Танд цахим эмнэлгийн хуудас олгосон бол хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад цахимаар гаргана.

Харин эмнэлгийн хуудсыг цахимаар бичүүлсэн боловч даатгуулагч өөрөө цахимаар хүсэлтээ гаргах боломжгүй бол харилцагч нийгмийн даатгалын байгууллагадаа өөрийн биеэр очиж хүсэлт гаргах боломжтой.

Эмнэлгээс миний эмнэлгийн хуудсыг ажил олгогчид илгээсэн. Би тэтгэмж авах хүсэлтээ хэрхэн гаргах вэ?

Эрүүл мэндийн байгууллагаас цахимаар илгээсэн эмнэлгийн хуудсыг үндэслэн Таны ажил олгогч тэтгэмж авах мэдээллийг шимтгэлийн цахим системд оруулан баталгаажуулж, Нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

Цэргийн алба хаагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлтээ хэрхэн гаргах вэ?

Цэргийн алба хаагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг цахимаар бичүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагаас тухайн эхийг ажиллуульж байгаа цэргийн анги, байгууллагад илгээнэ.

Даатгуулагчийн веб <https://daatguulagch.ndaatgal.mn> -д бүртгүүлсэн и-мэйл хаяг, мэдээллээ мартсан бол хаана хандах вэ?

Та 9590-1289, 9490-1289 утсанд хандаж эсвэл “**Нийгмийн даатгалын мэдээлэл зөвлөгөө**” фэйсбүүк хуудсаар бүртгэлийн мэдээллээ сэргээх боломжтой.